

БАТЛАВ
БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б. АМГАЛАНБАДРАХ

**БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ДАЛТ, БҮРЭНХАЙРХАН
БАГУУДАД ГЭРЭЛТҮҮЛЭГ НИЙЛҮҮЛЭХ ,ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ
БИЧИГ**

Тендер
шалгаруулалтын нэр

Гэрэлтүүлэг хийх нийлүүлэх

Тендерийн дугаар

ХОАБУСЗДТГ/2020010

2020 он

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.08.26

Ховд аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Баянгол багийн улаан булан барих хийх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 00 минут**-аас / **Орон нутгийн цагаар**/ өмнө **tender.gov.mn** –р ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 08 дугаар сарын 26** -ны өдрийн **10 цаг 00 минутанд / орон нутгийн цагаар**/ нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Ховд аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газар
2 давхар 210 тоот сан хариуцсан нягтлан бодогч Д.Батцэцэг, Утас: 99753690,88562044
www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>-Сүүлийн 1 жил буюу 2019 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх</p> <p>-Сүүлийн 1 жилийн буюу 2019 оны ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл, хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, хүлээлгэн өгсөн акт.</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар - Татварын өргүй болохыг тодорхойлсон тодорхойлолт - Нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхойлолт - Шүүхийн байгууллагын тодорхойлолт - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт - Харилцагч банкины өргүй болохыг тодорхойлсон мэдэгдэл <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Шаардлагагүй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: www.tender.gov.mn Давхар болон өрөөний дугаар:</p> <p>Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 02 -ны өдөр</p> <p>Цаг: Орон нутгийн цагаар 10 цаг 00 минут, Улаанбаатар хотын цагаар 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Ховд аймгийн Булган сумын ЗДТГ Давхар болон өрөөний дугаар: 2 давхар 210 тоот</p> <p>Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 02-ний өдөр</p> <p>Цаг: Орон нутгийн цагаар 10 цаг 00 минут, Улаанбаатар хотын цагаар 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

БАТЛАВ:

ЗАСАГ ДАРГА

Б.АМГАЛАНБАДРАХ

Булган сумын Далт,Бүрэнхайрхан багт гэрэлтүүлэг
суурьлуулах ажлын даалгавар

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Гарал үүсэл
1	Гэрэл	30 ш	Лед сайн чанрын Хятад
2	Утас	1200 м	Сайн чанрын Хятад
3	Гар	30ш	Төмөр хийцтэй Хятад
5	Суурь төмөр	25ш	Сайн чанрын Хятад
6	Төв шийд	1ш	Зориулалтын хайрцагтай ус бороо нэвтрэхгүй Хятад

- 1. Барааны тодорхойлолт:** Бараа нь техникийн тодорхойлолтод тусгагдсан үзүүлэлт, хүчин чадал шаардлагыг хангасан шинэ бараа бүтээгдэхүүн байна.
- 2. Стандарт:** Монгол Улсын болон олон улсын стандартад нийцсэн байна.
- 3. Баглаа, боодол:** Тоног төхөөрөмж нь сав баглаа боодолтой, тээвэрлэлтийн болон хадгалалтын нөхцөл шаардлагыг хангасан байх ба тээвэрлэлт, хадгалалтаас үүссэн гэмтлийг нийлүүлэгч хариуцна.
- 4. Бараа хүргэх газар:** Ховд аймаг Булган сум
- 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

- 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **20** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 9.1. Алданги оногдуулах хувь: **0.05%**
- Алдангийн нийт дүн: 10 хувиас тус тус хэтрэхгүй

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ЗАСАГ

ДАРГА

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

Б. АМГАЛАНБАДРАХ

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

**Булган сумын засаг даргын Тамгын газарт гэрэлтүүлэг нийлүүлэх
ажлын гэрээ.**

Дугаар № ХОАБУСЗДТГ/2020010

Ховд аймаг

Нэг талаас **Ховд аймгийн Булган сумын засаг даргын тамгын газар** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож **2020** оны **,,,** сарын **,,,**-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **Ховд аймгийн Булган сумын ЗДТГ ХОАБУСЗДТГ/20200**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Нийлүүлэгч нь **Ховд аймгийн Булган суманд хогны машин нийлүүлэх ХОАБУСЗДТГ/2020** нэр төрлийн барааг **2020** оны **,,, дугаар** сарын **,,**-наас **2020** оны **,,, дугаар** сарын **,,,**-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

4. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

5. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

6. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]